



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/28

Даланзадгад

Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж  
хуваарилах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/119 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж буюу вакцин хадгалах мөсөн ханатай хөргөгч, тог тохируулагчийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилсан хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэн авч ашиглалтад хяналт тавьж, ашиглалтад тогтмол хөтөлгөө хийж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын  
2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн  
А/28 тоот тушаалын хавсралт



ХҮЙТЭН ХЭЛХЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Мөсөн ханатай хөргөгч <b>VESTFROST VLS-064A RF AC</b>			Тог тохируулагч		
		Тоо	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/	Тоо	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Сэврэй ЭМТ	1	4.169.863	4.169.863			
2	Шимбилэг ӨЭМТ	1	4.169.863	4.169.863			
3	Мандал-Овоо СЭМТ				1	251.212	251.252
4	Өнө-Орших ӨЭМТ				1	251.212	251.252

Хуваарилалт хийсэн: НЭМТ-ийн дархлаажуулалт хариуцсан  
мэргэжилтэн Г.Мөнхзул